



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 10

Шарга

Төсвийн урамшуулал зарцуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн IY хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. 2013 оны төсвийн хэмнэлт 1873448 төгрөгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн Гэрээт ажлын цалингийн зардалд -1200000, Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд -132000, Төлбөр хураамж, жижиг татварын зардалд -541448 төгрөгийг тусган баталсугай.

2. Төсвийн урамшууллаар хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнг Хавсралтаар баталсугай.

3. Төсвийн зарцуулалт, үр дүнг тайлагнаж ажиллахыг Төсвийн ерөнхий менежерийн үүрэг гүйцэтгэгч /Ч.Мөнхцэцэг/, Ерөнхий нягтлан бодогч /Ж.Пүрэвжав/ нарт даалгасугай.

ДАРГА

Ч.АЗБАЯР

D: /2014 Togtool /ith/

00076

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн  
 10 дугаар тогтоолын Хавсралт

ТӨСВИЙН УРАМШУУЛЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР,  
 АРГА ХЭМЖЭЭ, ХҮРЭХ ҮР ДҮН

№	Хөтөлбөр арга хэмжээний дугаар	Хэрэгжүүлэх хөтөлбөр	Зорилтот түвшин		Төсөв /мянган төгрөг/	
			Чанар	Тоо		
	1	Иргэдийн хурлын дарга				
1	1.6.3	Нутгийн удирдлагын холбоотой ажлын уялдаагаа сайжруулах, гишүүн байгууллагын татварыг төлөх	Гишүүн байгууллагын татвар төлөгдсөн байх	1	50000	
2	1.6.3	Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран иргэдэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	200-аас доошгүй иргэнийг хамруулсан байх	2	491448	
3	1.7.7	Иргэний танхимыг хурлын дэргэд авч, ажлын албаны орон тоог нэмэгдүүлэх	1000- аас доошгүй иргэнд үйлчилсэн байх	1	1332000	
Дүн					1873448	

-----oOo-----